



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2019 оны 12 сарын 16 өдөр

Дугаар А/184

Ховд

Тооллогын комисс томилж,
тооллого хийх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2, 72 дугаар зүйлийн 72.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын хөрөнгийн тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Б.Нямдэлгэр - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, аж ахуйн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч

- Гишүүд:
- Б.Энхмандал - Аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч
 - Х.Болормаа - Аймгийн Засаг даргын Тамгын газрын нярав
 - Б.Отгонцэцэг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн мэргэжилтэн
 - Б.Гантөмөр - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн Хяналт- шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
 - Д.Дөмөгтүшиг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны, удирдлагын хэлтсийн Цахим засаглал, мэдээллийн технологи, сүлжээний асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Үндсэн хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр хөрөнгийг тоолж, тооллогын дүнгийн талаар “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийг хэлэлцүүлэн өөрчлөгдсөн дутагдсан үрэгдүүлсэн, элэгдсэн муудсан, шаардлага хангахгүй

02 00940

болсон эд хөрөнгө байгаа эсэх талаар дүгнэлт гаргаж, тус онд шинээр авсан эд хөрөнгийг балансанд тусган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/-д үүрэг болгосугай.

3. Тооллогын бэлтгэл ажлыг хангаж ашиглалтын хугацаа дууссан, чанарын шаардлага хангахгүй эд хөрөнгө тогтоогдвол тэдгээрийг актлах, устгахыг холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /Б.Энхмандал/-д даалгасугай.

4. Тушаалыг ажлын хэсэгт танилцуулсугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД